## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2025/013/НА-СТА-ТШЗ

---


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn


Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум

2025 он

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.11 № 1/75

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Э.УЛАМ-ӨСӨХ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус суманд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой төрийн байгууллагуудаас зудын хандивт 5,340.0 мянган төгрөг хүлээн авч, өвс тэжээл бэлтгэх болон түлш, шатахууны зардалд зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар нийт 30,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил[1] илэрснээс 30,000.0 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

### Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд “Хүүхэд хамгаалал, хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд “Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилтын дор 5 дэд зорилт, 101 ажил, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг өөрийн үнэлгээгээр 98.7 хувь хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6725041135

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **284,021,419.00** | **374,706,783.92** |
| **33** | **АВЛАГА** | **10,496,041.00** | **11,399,691.67** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 2,766,191.67 |
| **335** | **Бусад авлага** | **10,496,041.00** | **8,633,500.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 8,329,500.00 | 7,850,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,166,541.00 | 783,500.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **1,985,000.00** | **2,900,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 1,985,000.00 | 2,900,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **271,540,378.00** | **360,407,092.25** |
| **354** | **Хангамжийн материал** | **269,075,378.00** | **358,042,092.25** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,492,378.00 | 4,408,110.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 123,876,265.00 | 129,832,258.25 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,320,000.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 3,360,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 23,284,350.00 | 18,691,930.00 |
| 35460 | Хүнсний материал | 17,500.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 116,084,885.00 | 201,749,794.00 |
| 35600 | Мал амьтад | 2,465,000.00 | 2,365,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,155,672,170.19** | **1,855,205,801.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,155,672,170.19** | **1,855,205,801.11** |
| **392** | **Биет хөрөнгө** | **972,015,670.27** | **1,671,618,051.23** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 858,845,317.40 | 1,439,454,678.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -320,607,944.76 | -366,160,191.27 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 355,668,311.00 | 433,668,311.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -211,153,938.45 | -277,373,950.09 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 261,997,633.80 | 418,434,233.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -151,492,575.47 | -187,170,785.83 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 88,724,100.00 | 113,066,550.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,956,999.76 | -52,429,941.17 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 257,260,078.40 | 295,910,078.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -124,268,311.89 | -145,780,932.01 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **183,656,499.92** | **183,587,749.88** |
| 39301 | Программ хангамж | 3,185,000.00 | 3,185,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,047,500.08 | -3,116,250.12 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 183,519,000.00 | 183,519,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,439,693,589.19** | **2,229,912,585.03** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,439,693,589.19** | **2,229,912,585.03** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,439,693,589.19** | **2,229,912,585.03** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 703,146,831.77 | 703,146,831.77 |
| 51101 | Өмч: - төрийн | 703,146,831.77 | 703,146,831.77 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **504,174,060.93** | **1,294,393,056.77** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 504,174,060.93 | 504,174,060.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 790,218,995.84 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 232,372,696.49 | 232,372,696.49 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,439,693,589.19** | **2,229,912,585.03** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,224,007,957.32** | **2,390,580,437.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **201,841,938.60** | **973,602,803.25** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **201,841,938.60** | **964,262,803.25** |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 201,841,938.60 | 964,262,803.25 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,514,500.00 | 00.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 133,984,701.60 | 850,153,012 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 64,342,737.00 | 114,109,791.25 |
| **122** | **Тусламжийн орлого** | **00.00** | **9,340,000.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 9,340,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,022,166,018.72** | **1,416,977,634.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **43,883,418.72** | **75,636,534.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 87,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,106,242.00 | 65,124,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,690,176.72 | 10,511,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **978,282,600.00** | **1,341,341,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 978,282,600.00 | 1,341,341,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,144,132,062.44** | **1,597,752,862.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,138,085,062.44** | **1,596,522,862.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,053,405,155.39** | **1,420,532,124.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **475,469,611.48** | **761,434,017.74** |
| 210101 | Үндсэн цалин | 311,502,780.60 | 432,880,871.82 |
| 210102 | Нэмэгдэл | 110,004,820.31 | 271,652,945.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 22,385,500.00 |
| 210104 | Урамшуулал | 53,962,010.57 | 34,514,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **59,531,733.05** | **95,692,176.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,625,688.69 | 65,725,842.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,779,492.72 | 7,732,452.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,819,194.35 | 3,820,026.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 937,016.17 | 3,682,771.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,370,341.12 | 14,731,084.22 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **69,970,338.88** | **72,475,156.10** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,074,239.85 | 14,564,962.41 |
| 210302 | Түлш, халаалт | 57,385,599.00 | 56,688,693.69 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,510,500.03 | 1,221,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **116,227,427.12** | **82,091,572.13** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,553,210.00 | 6,164,968.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 55,652,388.00 | 28,295,410.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,027,568.61 | 3,671,813.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 176,400.00 | 189,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,696,548.60 | 13,868,741.13 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 983,817.91 | 3,854,640.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,101,994.00 | 1,183,400.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 30,035,500.00 | 24,863,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **480,000.00** | **308,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 480,000.00 | 308,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,538,317.00** | **45,212,010.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 25,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,538,317.00 | 45,187,010.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,395,000.00** | **6,288,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,395,000.00 | 6,288,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **33,418,627.00** | **21,438,543.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,220,816.00 | 18,427,760.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 580,000.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 450,000.00 | 448,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 308,830.00 | 650,882.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 67,344.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 395,000.00 | 418,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 396,637.00 | 240,301.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **282,374,100.86** | **335,592,649.41** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,992,250.05 | 154,345,214.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,280,000.00 | 960,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 169,101,850.81 | 180,287,435.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **84,679,907.05** | **175,990,737.86** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,544,319.00** | **58,843,942.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,920,959.00 | 25,417,042.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 28,214,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,623,360.00 | 5,212,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **72,135,588.05** | **117,146,795.86** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,135,588.05 | 117,146,795.86 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,047,000.00** | **1,230,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **6,047,000.00** | **1,230,000.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **79,875,894.88** | **792,827,574.84** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **2,991,875.03** | **00.00** |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 2,991,875.03 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **2,249,429.57** | **2,608,579.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,249,429.57 | 2,608,579.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **742,445.46** | **-2,608,579.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **80,618,340.34** | **790,218,995.84** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,072,886,005.00** | **1,540,653,682.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,270,000.00** | **5,340,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **13,270,000.00** | **00.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **13,270,000.00** | **00.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,270,000.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **00.00** | **5,340,000.00** |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 5,340,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,059,616,005.00** | **1,535,313,682.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **81,333,405.00** | **193,972,582.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 87,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 15,000,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,106,242.00 | 65,124,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 43,140,163.00 | 128,847,748.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **978,282,600.00** | **1,341,341,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 978,282,600.00 | 1,341,341,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **920,325,705.00** | **1,431,237,732.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **920,325,705.00** | **1,431,237,732.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **835,644,157.95** | **1,255,246,994.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **475,469,611.48** | **762,179,731.50** |
| 210101 | Үндсэн цалин | 309,152,668.06 | 430,446,644.20 |
| 210102 | Нэмэгдэл | 112,394,471.33 | 276,319,845.78 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 23,289,440.00 |
| 210104 | Урамшуулал | 53,922,472.09 | 32,123,801.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **59,274,760.33** | **95,125,827.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,368,895.97 | 64,978,673.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,779,492.72 | 7,644,826.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,819,194.35 | 3,822,563.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 937,016.17 | 3,695,629.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,370,161.12 | 14,984,135.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **69,957,838.88** | **73,883,578.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,074,239.85 | 15,344,855.90 |
| 210302 | Түлш, халаалт | 57,385,599.00 | 57,317,222.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,498,000.03 | 1,221,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **51,024,737.21** | **73,049,761.13** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,887,000.00 | 4,711,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,795,640.00 | 44,589,420.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,027,568.61 | 4,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 176,400.00 | 189,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,380,728.60 | 13,871,741.13 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 757,400.00 | 5,688,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **480,000.00** | **1,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 480,000.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,989,054.00** | **19,864,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,017,500.00 | 1,885,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,950,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,971,554.00 | 15,029,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,395,000.00** | **6,288,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,395,000.00 | 6,288,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **81,728,240.00** | **26,271,363.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79,270,429.00 | 23,253,880.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 580,000.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 450,000.00 | 448,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 308,830.00 | 627,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 67,344.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 655,000.00 | 448,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 396,637.00 | 240,301.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **85,324,916.05** | **197,584,232.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,864,916.05 | 196,624,232.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,460,000.00 | 960,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **84,681,547.05** | **175,990,737.86** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,545,959.00** | **58,843,942.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,920,959.00 | 25,417,042.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 28,178,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,625,000.00 | 5,248,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **72,135,588.05** | **117,146,795.86** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,135,588.05 | 117,146,795.86 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **152,560,300.00** | **109,415,950.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **152,560,300.00** | **109,415,950.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **152,560,300.00** | **109,415,950.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **152,560,300.00** | **109,415,950.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 114,833,900.00 | 77,492,650.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 37,726,400.00 | 31,923,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-152,560,300.00** | **-109,415,950.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **703,146,831.77** | **234,401,236.49** | **419,883,837.79** | **1,357,431,906.05** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **703,146,831.77** | **234,401,236.49** | **421,912,377.79** | **1,359,460,446.05** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 80,618,340.34 | 80,618,340.34 |
| **C08** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **703,146,831.77** | **232,372,696.49** | **504,174,060.93** | **1,439,693,589.19** |
| **D01** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **703,146,831.77** | **232,372,696.49** | **504,174,060.93** | **1,439,693,589.19** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **703,146,831.77** | **232,372,696.49** | **504,174,060.93** | **1,439,693,589.19** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 790,218,995.84 | 790,218,995.84 |
| **D09** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **703,146,831.77** | **232,372,696.49** | **1,294,393,056.77** | **2,229,912,585.03** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,245,047,900.0 | 1,146,201,654.1 | 98,846,245.9 | 92.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,245,047,900.0 | 1,146,201,654.1 | 98,846,245.9 | 92.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,216,054,500.0 | 1,118,454,412.1 | 97,600,087.9 | 92.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 767,767,600.0 | 762,179,731.5 | 5,587,868.5 | 99.3 |
| 210101 | Үндсэн цалин | 502,958,200.0 | 430,446,644.2 | 72,511,555.8 | 85.6 |
| 210102 | Нэмэгдэл | 215,459,400.0 | 276,319,845.8 | -60,860,445.8 | 128.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,350,000.0 | 23,289,440.0 | 2,060,560.0 | 91.9 |
| 210104 | Урамшуулал | 24,000,000.0 | 32,123,801.5 | -8,123,801.5 | 133.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 95,972,500.0 | 95,125,827.4 | 846,672.6 | 99.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,260,800.0 | 64,978,673.1 | 282,126.9 | 99.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,677,700.0 | 7,644,826.3 | 32,873.8 | 99.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,839,300.0 | 3,822,563.1 | 16,736.9 | 99.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,839,300.0 | 3,695,629.1 | 143,670.9 | 96.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,355,400.0 | 14,984,135.8 | 371,264.2 | 97.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79,900,000.0 | 73,883,578.6 | 6,016,421.4 | 92.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,200,000.0 | 15,344,855.9 | -3,144,855.9 | 125.8 |
| 210302 | Түлш, халаалт | 66,200,000.0 | 57,317,222.7 | 8,882,777.3 | 86.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.0 | 1,221,500.0 | 278,500.0 | 81.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,290,000.0 | 49,004,511.1 | 3,285,488.9 | 93.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,500,000.0 | 3,500,000.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,450,000.0 | 26,443,170.0 | 6,830.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,000,000.0 | 4,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.0 | 189,600.0 | 10,400.0 | 94.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 17,140,000.0 | 13,871,741.1 | 3,268,258.9 | 80.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Норматив зардал** | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27,159,000.0 | 26,479,300.0 | 679,700.0 | 97.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,061,000.0 | 11,901,300.0 | 159,700.0 | 98.7 |
| 210602 | Тавилга | 6,000,000.0 | 5,480,000.0 | 520,000.0 | 91.3 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 8,098,000.0 | 8,098,000.0 | 00.0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,300,000.0 | 6,288,000.0 | 12,000.0 | 99.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,300,000.0 | 6,288,000.0 | 12,000.0 | 99.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 103,162,000.0 | 41,148,363.5 | 62,013,636.5 | 39.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 99,047,000.0 | 38,130,880.5 | 60,916,119.5 | 38.5 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,300,000.0 | 1,209,600.0 | 90,400.0 | 93.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 450,000.0 | 448,000.0 | 2,000.0 | 99.6 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800,000.0 | 627,582.0 | 172,418.0 | 78.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,000.0 | 44,000.0 | 121,000.0 | 26.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.0 | 448,000.0 | 552,000.0 | 44.8 |
| 210807 | Газрын төлбөр | 400,000.0 | 240,301.0 | 159,699.0 | 60.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 82,503,400.0 | 63,345,100.0 | 19,158,300.0 | 76.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,503,400.0 | 63,185,100.0 | 17,318,300.0 | 78.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.0 | 160,000.0 | 1,840,000.0 | 08.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,993,400.0 | 27,747,242.0 | 1,246,158.0 | 95.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,993,400.0 | 27,747,242.0 | 1,246,158.0 | 95.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,680,300.0 | 25,417,042.0 | 263,258.0 | 99.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,313,100.0 | 2,330,200.0 | 982,900.0 | 70.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 96,293,200.0 | 78,352,650.0 | 17,940,550.0 | 81.4 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 96,293,200.0 | 78,352,650.0 | 17,940,550.0 | 81.4 |
| 223001 | Бусад хөрөнгө | 96,293,200.0 | 78,352,650.0 | 17,940,550.0 | 81.4 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,341,341,100.0 | 1,224,554,304.1 | 116,786,795.9 | 91.3 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,224,194,304.1 | 1,224,194,304.1 | 00.0 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,224,194,304.1 | 1,224,194,304.1 | 00.0 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 117,146,795.9 | 00.0 | 117,146,795.9 | 00.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 117,146,795.86 | 00.00 | 117,146,795.86 | 00.0 |
| 1200044 | Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 360,000.00 | -360,000.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 00.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 09.00 | 09.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 00.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **198,952,582.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **198,952,582.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **167,855,882.00** |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 24,045,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,211,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,146,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,688,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,631,500.00 |
| 210602 | Тавилга | 700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,931,500.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 136,179,132.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 135,379,132.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,096,700.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,096,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,178,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,917,900.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 193,612,582.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 193,612,582.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,124,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 128,487,748.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,151.0 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад 73,151.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ нь тайлант онд Бараа материалын данс хооронд 56,361.0 мянган төгрөгийн бараа материал ангилал зөрүүлж бүртгэсэн, АЗДТГ-аас шилжиж ирсэн 8,690.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, Авто тээврийн хэрэгслийн ашиглалтын жилийг буруу бүртгэснээс 5,200.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг илүү тооцоолсон, хүлээж аваагүй бараа материалыг бүртгэж, 2,900.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1[2], 14 дүгээр зүйлийн 14.4. *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.2[3], НБББББ-ийн 5.4.*"**Үндсэн хөрөнгө** хэсгийн 7 дугаарт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг баримтлаагүй"*, 5.9. *"Зардлын*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө"

[3] "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;"

*бүртгэл хэсгийн 4*[4] *дүгээрт Зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ хэсэгт заасанд тус тус нийцэхгүй",* Ангилал, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт, Оршин байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 2 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 30,000.0 мянган төгрөгийн 1 зөрчил[5] илэрснээс 30,000.0 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүлсэн.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар:

*Илрүүлэлт* Өвөлжилт хүндэрсэн малчин болон мал бүхий өрхөд буцалтгүй тусламж олгохоор хивэг худалдан авах зориулалтаар ЗДТГ-ын урд оны үлдэгдлээс 30,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Хивэг худалдан авахдаа гэрээ шууд байгуулах аргыг мөрдөөгүй шууд худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "*Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно:*" гэж заасан нөхцөл[6]-үүдэд тендер зохион байгуулах аргыг хэрэглээгүй, 35.4[7]-т заасан хугацааг баримтлаагүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна..

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах.

2. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудлаар:

*Илрүүлэлт:* Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5[8] заасан бүрдлийн дагуу ирүүлээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

[4] "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын данснуудад хуримтлуулан бүртгэнэ. Аккруэл суурьт бүртгэлийн дагуу ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ."

[5] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[6] 35.1.1.захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;
Тайлбар:Энэ заалтын дагуу гэрээ шууд байгуулахад өмнөх тендер шалгаруулалт амжилтгүй болсон, захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан, эсхүл төсвийн жил дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал хамаарахгүй.
35.1.2.онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;
35.1.3.шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал.

[7] "Хэлэлцээнд оролцох сонирхлоо илэрхийлэх хугацааг зарлал нийтэлж, урилга хүргүүлснээс хойш ажлын таван өдөр байхаар, хэлэлцээ эхлүүлэх хугацааг сонирхлоо илэрхийлэх эцсийн хугацаанаас хойш ажлын гурваас доошгүй өдөр байхаар зарлал, урилгад тус тус заана."

8 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:"
54.5.1.тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнге оруулалтын арга хэмжээ бүрээр/;
54.5.2.татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;
54.5.3.тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;
54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

*Өгсөн зөвлөмж*: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлж байх.

*Илрүүлэлт*: Тайлант онд УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатараас өгсөн гэх Jimny автомашин, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс төрийн сангийн мэргэжилтэнд шилжиж очсон notebook-г анхан шатны баримт, үнэлгээ, шийдвэргүй ирсэн тул данс бүртгэлд тусгаагүй ашиглаж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;*" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилжиж ирсэн хөрөнгийн шийдвэр, анхан шатны баримтыг бүрдүүлж, данс бүртгэлд бүртгэх, Тайлангийн тодруулгад энэ талаар тусгах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын ангилал зөрүүлж бүртгэсэн | 1 | 56,361.0 | | | 1 | 56,361.0 | 1 | 56,361.0 | | | | |
| Шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй | 1 | 8,690.0 | 1 | 8,690.0 | | | 1 | 8,690.0 | | | | |
| Хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй тооцоолсон | 1 | 5,200.0 | | | 1 | 5,200.0 | 1 | 5,200.0 | | | | |
| Зардлыг бараа материалаар бүртгэсэн | 1 | 2,900.0 | | | 1 | 2,900.0 | 1 | 2,900.0 | | | | |
| **Дүн** | **4** | **73,151.0** | **1** | **8,690.0** | **3** | **64,461.0** | **4** | **73,151.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүү, бүртгэлтэй холбоотой | | | | | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Тайлант онд хүлээн авч ашиглаж байгаа | 1 | 0 | | | | | 1 | 0 |

---

54.5.5.нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга.

54.5.6.Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Мөнхбаатар гишүүнээс өгсөн гэх Jimny автомашин, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс төрийн сангийн мэргэжилтэнд шилжиж очсон notebook хөрөнгүүд нь анхан шатны баримт, үнэлгээ, шийдвэргүй ирсэн тул данс бүртгэлд тусгаагүй ашиглаж байна. | | | | | | | | |
| Дүн | **2** | **0** | | | | | **2** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжтой холбоотой | | | | | | | | |
| ЗДТГ-ын урд оны үлдэгдлээс 30.0 сая төгрөгийг өвөлжилт хүндэрсэн малчин болон мал бүхий өрхөд буцалтгүй тусламж олгохоор хивэг худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 30,000.0 | | | | | 1 | 30,000.0 |
| Дүн | **1** | **30,000.0** | | | | | **1** | **30,000.0** |